



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.02.01 № А-1/209  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Төсөл, арга хэмжээний тухай**

Тус газраас 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зарласан XVII.1.32 Бичигт, Алагтолгой, Баатархайрхан, Тахилт, Бугат, Буянт, Хайрхан багуудын цахилгаан хангамж /Ховд, Жаргалант сум/ төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын нээлтийг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр хийхээр товлосон байсан боловч захиалагч Эрчим хүчний яамны 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн в/369 дүгээр албан бичгээр " ... XVII.1.32 Бичигт, Алагтолгой, Баатархайрхан, Тахилт, Бугат, Буянт, Хайрхан багуудын цахилгаан хангамж /Ховд, Жаргалант сум/ төсөл арга хэмжээний ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орох нөхцөл байдал үүсээд байгаа тул 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр нээх тендер шалгаруулалтын нээлтийг түр хойшлуулж, зохих хууль тогтоомжид нийцүүлэн хугацааг сунгаж өгнө үү." гэж манайд мэдэгдсэн тул тухайн төсөл, арга хэмжээний тендер нээх хугацааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулж байна.

Захиалагчаас ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулан ирүүлсэн даруйд тухайн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах болно.

Эрчим хүчний яамны 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн в/369 дүгээр албан бичгийг хавсаргав.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1324020662

ТХААГ-2024-А4



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060  
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,  
Цахим шуудан: info@energy.gov.mn

2024.02.01 № 8/369  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
ДАРГА Ц.БАТЗУЛ ТАНАА**

Төсөл, арга хэмжээний тухай

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн Эрчим хүчний сайдын багцад батлагдсан, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Жагсаалт батлах тухай” 409 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар танай газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан XVII.1.32 Бичигт, Алагтолгой, Баатархайрхан, Тахилт, Бугат, Буянт, Хайрхан багуудын цахилгаан хангамж /Ховд, Жаргалант сум/ УТ2403000738 дугаартай төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зарласан.

Дээрх төсөл, арга хэмжээний Буянт багийн ажил нь батлагдсан зураг, төсвийн дагуу орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа тухай мэдээллийг Ховд аймгийн Цахилгаан түгээх сүлжээ ХХК-аас 2024 оны 22 тоот албан бичгээр тус яаманд ирүүлээд байна.

Иймд XVII.1.32 Бичигт, Алагтолгой, Баатархайрхан, Тахилт, Бугат, Буянт, Хайрхан багуудын цахилгаан хангамж /Ховд, Жаргалант сум/ УТ2403000738 дугаартай төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орох нөхцөл байдал үүсээд байгаа тул 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр нээх тендер шалгаруулалтын нээлтийг түр хойшлуулж, зохих хууль тогтоомжид нийцүүлэн хугацааг сунгаж өгнө үү.

Хүндэтгэсэн,

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Н.ТАВИНБЭХ

170600000364